



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/79.

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 03 сарын 05-ны өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Өндөршил” омгийн адуу, “Сайнцагаан” омгийн хонь, “Олдохын хүрэн бор” омгийн тэмээг шинжлэх ухааны үндэслэлтэй батлуулан бататгахад удирдлага, арга зүйгээр хангаж ажилласан Монгол Улсын зөвлөх мал зүйч Норовын Сүхээгийн орон нутгийн брэндийг бий болгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлэн хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 263,300 (хоёр зуун жаран гурван мянга гурван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Зардлын төрлийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

• 681210240